

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2025 оны 03 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2025.03

ДНБ-ий өсөлт

(2024 он)

4.9 хувь

Гадаад валютын нөөц

(2025 оны 3 дугаар сар)

4,996 сая \$

Инфляц

(2025 оны 3 дугаар сар)

9.1 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2025 оны 3 дугаар сар)

-353 тэрбум ₮

Экспорт

(2025 оны 3 дугаар сар)

3,013 сая \$

Импорт

(2025 оны 3 дугаар сар)

2,548 сая \$

ГШХО

(2024 он)

4,005 сая \$

Зээлийн хүү

(2025 оны 2 дугаар сар)

17.1 хувь

Ажилчдын тоо

(2024 оны 4 дүгээр улирал)

1.35 сая

*IV улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62.2 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2024 оны 4 дүгээр улирал)

7.9 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны эцэс)

108.4 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.


Өрхийн бодит орлогын өсөлт

(2024 оны 4 дүгээр улирал)

5.9 хувь



Монгол Улсын эдийн засаг 2024 онд 4.9 хувиар өсөж, нэрлэсэн ДНБ 80 их наяд төгрөгт, нэг хүнд ногдох ДНБ 6,890 ам.долларт хүрлээ. Худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил болон татварын орлого сайн байсан нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Харин хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын уналт өсөлтийг хязгаарлав.



- Бодит ДНБ 2024 онд **4.9 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Уул уурхайн салбар 10.8 хувиар тэлж, өсөлтийн 1.4 хувийг бүрдүүлсэн бол ХАА-н салбар 28.7 хувиар агшиж, нийт өсөлтийг -3.6 нэгж хувиар хязгаарлалаа.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 2.5 хувиар өсөж өсөлтийн 0.3 нэгж хувийг;
- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 9.8 хувиар өсөж өсөлтийн 4.8 хувийг;
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 16.1 хувиар өсөж өсөлтийн 2.0 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.
- 2024 онд худалдааны үйлчилгээний салбарын идэвх сайн байж, татварын орлого нэмэгдэн, эдийн засгийн өсөлтийг голлон дэмжив.
- Харин том малын зүй бус хорогдол оны эхнээс нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбар уналттай байв.
- Уул уурхайн салбар 2024 онд 10.8 хувиар өсөв.
- Нүүрс олборлолт 100.1 сая тоннд хүрч, өмнөх оноос 23 хувиар өссөн нь гол нөлөөллөө.
- Мөн зэсийн баяжмалын үйлдвэрлэл 12 хувиар, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалын олборлолт 32 хувиар нэмэгдсэн байна.
- Харин алт болон газрын тосны олборлолт тус тус 15 болон 14 хувиар буурч, тус салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлөв.
- ХАА-н салбар 2024 онд улиралд 28.7 хувиар агшлаа.
- Том малын зүй бус хорогдол 9.4 сая толгойд хүрч өмнөх оноос 4.4 сая толгой малаар нэмэгдсэн байна. Энэ нь 2024 оны эхэнд тоологдсон нийт малын 14.5 хувьд хүрч, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл жил дараалан буурлаа.
- Нийт малын тоо 57.6 сая толгой болж, 2015 онтой ойролцоо түвшинд хүрлээ.
- Нийт тариалсан талбай өнгөрсөн оноос 1.5 хувиар, хураасан улаан буудай 5.4 хувиар тус тус буурлаа.

1.2 ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)

2024 оны 4 дүгээр улирал


PMI индекс тэлэлтийн төлөвт хадгалагдаж 58.5 хувь гарсан ч өмнөх улирлаас 2.5 нэгж хувиар буурлаа.

PMI
(50=өөрчлөлтгүй)




Эх сурвалж: Монголбанк

PMI, гол салбараар
(50=өөрчлөлтгүй)




Эх сурвалж: Монголбанк

PMI, аж ахуй нэгжийн төрлөөр
(50=өөрчлөлтгүй)



Эх сурвалж: Монголбанк

PMI, үзүүлэлтүүдээр
(50=өөрчлөлтгүй)



Эх сурвалж: Монголбанк

- Үйлдвэрлэл, эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг хэмждэг Худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2024 оны 4 дүгээр улиралд 58.5 хувь болж, өмнөх улирлаас 2.5 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар тус тус суларсан байна.

- Барилгаас бусад салбарын бизнесүүд эерэг хүлээлттэй байна.
- Уул уурхайн өсөлтийн нөлөөгөөр аж үйлдвэрийн салбарын PMI хамгийн өндөр буюу 63.4 хувь байна.
- Харин үйлчилгээний салбаруудын PMI өмнөх улирлаас 8.6 нэгж хувиар буурч, 54.7 хувь болсон байна.
- Худалдааны салбарын PMI 2.8 нэгж хувиар сайжирч, 53.6 хувь болжээ.


- 200-гаас дээш ажиллагсадтай том аж ахуй нэгжүүдийн PMI индекс 63.2 хувь болж, өмнөх улирлаас 1.8 нэгж хувиар муудав.
- Харин 50-199 ажиллагсадтай дунд хэмжээтэй аж ахуй нэгжүүдийн хувьд өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар дээшилж 50.1 хувь болж, эерэг төлөвт шилжжээ.
- Харин жижиг бизнесүүд сөрөг хүлээлттэй хэвээр байна.

- Бизнесүүд шинэ захиалгын тоо, үйлдвэрлэлийн хэмжээ, бараа материалын нөөц, ажил эрхлэлт нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байгаа бол нийлүүлэлтийн хүргэлтийн хугацаа сүүлийн 16 улирлын турш уртассан гэж хариулсан байна.




Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 онд 5.0 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжсэн бол хэрэглээ, хөрөнгө оруулалтын идэвхжилийг даган бараа, үйлчилгээний импорт нэмэгдсэн нь нийт өсөлтийг сааруулав.

ДНБ ӨСӨЛТИЙН БҮТЭЦ
(жилийн өсөлтийн хувь)



- Эдийн засгийн өсөлтөд дотоод эрэлт голлон нөлөөлөв. Нийт өсөлтийн 8.6 нэгж хувийг өрхүүдийн хэрэглээ, 3.6 нэгж хувийг засгийн газрын хэрэглээ, 6.2 нэгж хувийг хөрөнгө оруулалт бүрдүүлсэн байна.
- Харин импортын эрчимтэй өсөлт цэвэр экспортыг бууруулж, өсөлтөд сөргөөр нөлөөллөө.

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН
ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)




- Төрийн хэрэглээний өсөлт 2024 оны сүүлийн хагаст саарч, жилийн дүнгээр 18.3 хувьд хүрэв.
- Цалин, тэтгэвэр, тэтгэмж өссөний зэрэгцээ хэрэглээний зээл олголт нэмэгдсэн нь 2024 онд өрхийн хэрэглээг дэмжиж, өрхийн хэрэглээ урьдчилсан гүйцэтгэлээр 12.9 хувиар өссөн байна.

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН
БҮТЭЦ (жилийн өсөлтийн хувь)



- Үндсэн хөрөнгийн хуримтлал 19.7 хувиар өсөхөд уул уурхайн хүнд машин механизм болон авто зам зэрэг инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалт өссөн нь голлон нөлөөллөө.


ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)




- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 0.7 хувиар өссөн бол хэрэглээ, хөрөнгө оруулалт идэвхэжсэнээр бараа, үйлчилгээний импорт 17.7 хувиар өслөө.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний улиралд 17 хувиар өсөв. Уул уурхайн салбарт зэсийн баяжмалаас бусад бүтээгдэхүүн буюу нүүрс, төмрийн хүдэр, алт, газрын тос олборлолтын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс буурав. Мөн нүүрсний үнийн нөлөөгөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс буурсан байна.




- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний улиралд 7.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.0 хувиар өссөн байна.
- Зэсийн баяжмалын үйлдвэрлэлийн нөлөөгөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 18.6 хувиар нэмэгдлээ.
- Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл (нэрлэсэн дүнгээр) 2025 оны эхний улиралд 7.3 хувиар өсөхөд хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон химийн бодисын үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлөв.



- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 70 орчим хувийг* уул уурхайн салбар, түүн дотор 43 хувийг нь нүүрсний олборлолт эзэлдэг.
- Нүүрсний олборлолт 2025 оны эхний улиралд 19.7 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.4 хувиар буурсан байна.



- Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 2025 оны эхний улиралд нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 29 хувиар өсөж 448 мянган тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 1,429 мянган тоннд хүрч, 4 хувиар буурсан байна.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс доогуур байна.




- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2025 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өссөн байна.
- Үнэ өссөн:
- Ундаа үйлдвэрлэл 10.1 хувиар;
 - Тавилгаас бусад мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл 88.2;
 - Цахилгаан, хий, уур, агааржуулалт 68.5 хувиар тус тус өссөн бол
- Үнэ буурсан:
- Нүүрс олборлолт 14.5 хувиар;
 - Газрын тос олборлолт 9.1 хувиар
 - Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл 4.7 хувиар тус тус буурсан байна.


*2024 оны байдлаар




Боловсруулах салбарын үйлдвэрлэл 2025 оны 3 дугаар сард үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүнгээр 1.0 хувиар өслөө. Хөдөө аж ахуйн гаралтай мах, арьс шир, ноолуур, гурил зэрэг бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийн биет хэмжээ буурч, сүүний үйлдвэрлэл нэмэгдсэн байна.



- Боловсруулсан малын мах 2025 оны эхний 3 сард 8.2 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 22 хувиар буурлаа.
- Махны биет хэмжээний бууралтын нөлөөгөөр 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буураад байна.




- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 3 сард 40.0 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 15 хувиар буурлаа.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ буурсан голлох нөлөөгөөр боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг үр тарианы гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 23.3 хувиар буурлаа.




- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 3 сард 134.5 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар өслөө.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөн ч боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар буурлаа*.

*Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн бууралтын нөлөө.




- Ноолууран сүлжмэл эдлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 3 сард 62 мянган ширхэг болж, өмнөх оны мөн үеэс 28 хувиар буурлаа.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээний буурсан хэдий ч боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг нэхмэлийн бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оноос 20.4 хувиар өссөн байна.


Барилгын салбарын дотоодын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент, метал бэлдэц, метал цувималын үйлдвэрлэл буурч, вакум цонх, хаалганы үйлдвэрлэл нэмэгдлээ.




■ Цемент үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 3 сард 71.8 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 32 хувиар буурлаа.



■ Катодын зэс үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 3 сард 1,990 тонн болж, өмнөх оны мөн үеэс 13 хувиар буурлаа.



■ Метал бэлдэц болон цувимал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 3 сард 19.0 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурлаа.




■ Вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 3 сард 5.1 мянган м2 болж, өмнөх оны мөн үеэс 39 хувиар өслөө.

Төмөр замын ачаа тээвэр эхний 3 сарын байдлаар нүүрс болон газрын тосны олборлолт буурсантай холбоотойгоор буурсан үзүүлэлттэй байна. Мөн улсын хилээр орсон жуулчдын тоо 19 хувиар өссөн байна. Харин худалдаа, үйлчилгээний салбарын борлуулалтын орлого 2025 оны 2 дугаар сард сайжрав.



- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар эзэлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний 2 сард нэрлэсэн дүнгээр 9.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар өссөн байна. Харин үнийн нөлөөг засварласан бодит орлогын дүн 0.3 хувийн өсөлттэй байна.



- Зочид буудал болон нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний 2 сард нэрлэсэн дүнгээр 17.8 хувь болон 15.0 хувиар тус тус өссөн байна.
- Харин инфляц эрчимжсэнээр үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлогын дүн 1 хувиар өссөн бол нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 1.4 хувиар буурсан байна.

ТЭЭВЭР
(тээсэн ачаа, сая тонн)

	2024.03	2025.03	ӨМНӨХ ОНООС:
Төмөр зам	10.9	10.3	-6%
Уул уурхайн бүт.	7.9	7.2	-9%
Агаар*	2.2	2.0	-8%
	2023.12	2024.12	
Авто зам	69.9	85.2	22%
Уул уурхайн бүт.	66.9	81.9	22%

Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик нь улирлаар зарлагддаг.
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Төмөр замаар 2025 оны эхний улиралд 10.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 хувиар буурсан байна. Үүнд, нүүрс болон нефтийн бүтээгдэхүүний тээвэр буурсан нь гол нөлөөлөв.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 8 хувиар буурсан байна.
- Авто замаар 2024 онд 85.2 сая тонн ачаа тээвэрлэсний 81.9 сая тонн буюу 96 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.

*МЯНГАН ТОНН




- 2025 оны эхний улиралд Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 102.9 мянгад хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 хувиар өссөн байна.




2025 оны эхний 3 сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 5.6 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 465 сая ам.долларын ашигтай гарлаа.




- Экспорт 2025 оны 3 дугаар сард 3,013 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 17 хувиар буурлаа.
- Нийт экспортын 94 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 54 хувийг бүрдүүлж байна.



- Нүүрсний экспортын орлого 1,342 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 40 хувиар буурлаа.
- Зэсийн баямжалын экспортын орлого 930 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 46 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 167 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 22 хувиар буурлаа.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 128 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 11 хувиар буурлаа.



- 2025 оны 3 дугаар сарын байдлаар импорт 2,548 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өссөн байна.
- Нийт импортын 18 хувийг тоног төхөөрөмж, 20 хувийг нефть, 13 хувийг суудлын автомашин эзэлж байна.




- Тоног төхөөрөмжийн импорт 457 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар өслөө.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 519 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 325 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 29 хувиар өслөө.
- Барилгын материалын импорт 230 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 19 хувиар өслөө.

2.2 УУЛ УУРХАЙН ЭКСПОРТ

2025.03 сар




2025 оны 3 дугаар сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 94 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 88 хувийг бүрдүүллээ.




- Нүүрсний экспорт 2025 оны эхний 3 сард 17.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар буурлаа.



- Зэсийн баяжмалын экспорт 2025 оны эхний 3 сард 456 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 24.8 хувиар өслөө.




- Төмрийн хүдрийн экспорт 2025 оны эхний 3 сард 915 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар буурлаа.




- Газрын тосны экспорт 2025 оны эхний 3 сард 1,768 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар буурлаа.



2025 оны эхний 3 сард голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.




■ Малын махны экспорт 2025 оны эхний 3 сард 29 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 45 хувиар буурлаа.



■ Боловсруулсан арьс ширний экспорт 2025 оны эхний 3 сард 211 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 75 хувиар буурлаа.



■ Ноолуурын экспорт 2025 оны эхний 3 сард 17 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 34 хувиар буурлаа.



■ Ноосны экспорт 2025 оны эхний 3 сард 229 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 47 хувиар буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ
ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2025 оны 3 дугаар сарын дундаж үнэ 179 ам.долларт хүрч, өмнөх сараас 1 хувиар, өмнөх оны мөн үеэс 26 хувиар буурсан байна.

ЗЭС

(\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)




Эх сурвалж: Блүүмберг

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2025 оны 3 дугаар сарын дунджаар 9,092 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3 хувиар өссөн байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)




Эх сурвалж: Блүүмберг

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2025 оны 3 дугаар дундаж үнэ 100 ам.долларт хүрч, өмнөх сараас 1 хувиар, өмнөх оны мөн үеэс 5 хувиар буурсан байна.

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Брент)



Эх сурвалж: Блүүмберг


- Брент газрын тосны 2025 оны 3 дугаар сарын дундаж үнэ 68 ам.долларт хүрч өмнөх сараас 3 хувиар буурсан хэдий ч өмнөх оны мөн үеэс 13 хувиар өслөө.



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний 3 сард 678 мянган тонн нүүрс, 2.1 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 11.6 мянган тонн жоншны баяжмал, 4.5 мянган тонн зэсийн баяжмал арилжаалаад байна.



- 2025 оны 3 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 38.0 сая тонн нүүрс арилжиж, 4.6 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд 22.4 сая тонн нүүрс арилжиж, 2.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 3 сард 0.7 сая тонн нүүрс борлууллаа.



- 2025 оны 3 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 80 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 80 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 3 дугаар сард хэлцлийн доод үнэ 25 ам.доллар, дээд үнэ 115 ам.долларт хүрэв.



- 2025 оны 3 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 52 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 349 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2024 онд 2.4 сая тонн төмрийг арилжаалж, 167 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 3 сард 2.1 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.




- Төмрийн хүдэр болон баяжмалын 3 дугаар сарын дуудах дундаж үнэ 70 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 71 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 3 дугаар сард хэлцлийн доод үнэ 65 ам.доллар, дээд үнэ 89 ам.долларт хүрэв.

Төлбөрийн тэнцэл 2025 оны эхний 2 сард 742 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2025 оны 3 дугаар сарын эцэст өмнөх сараас 233 сая ам.доллороор нэмэгдлээ.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ


(сая ам.доллар)



Тэмдэглэл: Төлбөрийн тэнцлийн статистик 1 сарын хоцрогдолтой зарлагддаг.
Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ


(сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ


(төгрөг/ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА

(сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

- Төлбөрийн тэнцэл 2025 оны 2 дугаар сард 742 сая ам.долларын алдагдалтай гарлаа.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал дансны алдагдал 251 сая ам.доллараар их, санхүүгийн дансны ашиг 378 сая ам.доллараар бага байна.
- Засгийн газар 2025 оны 2 дугаар сард өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд 500 сая ам.долларын бондыг гадаад зах зээлд арилжааллаа.

- Гадаад валютын улсын нөөц 2025 оны 3 дугаар сарын эцэст 4,996 сая ам.доллар болж, өмнөх сараас 233 сая ам.доллороор нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 254 сая ам.доллороор буурлаа.

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 3 дугаар сард өдөрт дунджаар 1.2 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,488 төгрөгт хүрлээ.

- Төв банк 2025 оны 3 дугаар сард нийт 443 сая ам.долларыг зах зээлд нийлүүллээ.
- Улмаар 2025 оны эхний 3 сарын нийт дуудлага худалдаа 1.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 56.8 хувиар буюу 689 сая ам.доллараар өслөө.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн




Инфляц 2025 оны 3 дугаар сард 9.1 хувьд хүрч, өмнөх сараас 0.5 нэгж хувиар буурлаа. Инфляц өмнөх сараас буурахад хүнс болон хувцасны бүлгийн үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөлжээ. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 0.3 хувиар өссөн байна.



- Инфляц 2025 оны 3 дугаар сард улсын хэмжээнд 9.1 хувьд гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.5 нэгж хувь (27.1 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 6.6 нэгж хувь буюу 72.9 хувийг эзэлж байна.



- 2025 оны 3 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.3 хувиар өсөв.
- Үүнд мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх сараас 12.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2025 оны 3 дугаар сард суурь инфляц 8.8 хувь гарч, нийт инфляцын 5.8 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн сар буурсан үзүүлэлттэй байна.



- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2025 оны 3 дугаар сард жилийн инфляцын 17.7 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар буурлаа.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 22.3 хувиар өслөө.



Олон улсад чингэлэг тээврийн үнэ өмнөх оны мөн үеэс 19 хувиар буурчээ. Хүнсний үнийн индекс 2025 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



- Хүнсний инфляц 2025 оны 3 дугаар сард 8.4 хувь болж, нийт инфляцын 2.3 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хүнсний бус инфляц 9.2 хувь болж, нийт инфляцын 6.8 нэгж хувийг бүрдүүллээ. Хүнсний бус инфляц өмнөх сараас буурахад хувцас, бөс бараа, гутлын бүлэг болон тавилга, гэр ахуйн барааны бүлэг голлон нөлөөлсөн байна.



- Төгрөгийн амдоллартой харьцах ханш 2025 оны 3 дугаар сард дунджаар 3,475 төгрөг болж, өмнөх сараас 0.5 хувиар сулрав.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2024 оны 3 дугаар сарын байдлаар өмнөх сараас 0.2 хувиар өссөн байна.



- Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис/Суэцийн сувагт үүсээд буй халдлагаас үүдэлтэйгээр өсөөд байсан бол 2024 оны 2 дугаар хагасаас буурч эхэлсэн.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 2,265 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 19 хувиар буурсан байна.
- Чингэлэг тээврийн үнэ буурч, тогтворжиж байгаа нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг бууруулж байна.




- НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2025 оны 3 дугаар сард 127.1 болж, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн бол өмнөх сартай харьцуулахад өөрчлөгдөөгүй байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр мах, ургамлын тосны үнэ өссөн бол үр тариа, элсэн чихрийн үнэ буурч, сүүн бүтээгдэхүүний үнэ тогтвортой хадгалагдсан байна.




2025 оны 3 дугаар сард нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 6.4 их наяд төгрөг, нийт зарлага 6.5 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 353 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Нүүрсний үнийн бууралттай холбоотой төсөвт төвлөрөх орлого буурсан нь төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдалд голлон нөлөөлсөн байна.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ
(их наяд төгрөг)




- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны оны 3 дугаар сард 353 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, төсвийн тэнцэл өмнөх оноос 2.0 их наяд төгрөгөөр буурлаа.
- Нүүрсний үнийн бууралттай холбоотойгоор төсвийн орлого төвлөрүүлэлт саарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл алдагдалтай гарахад голлон нөлөөлсөн байна.

ТӨСВИЙН ОРЛОГО
(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)




- Төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 6.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөг буюу 16.2 хувиар буурсан байна.
- Бууралтад ААНОАТ 640 тэрбум төгрөг буюу 31.6 хувиар, НӨАТ 35.6 тэрбум төгрөг буюу 2.8 хувиар, нийт АМНАТ-ийн орлого 636 тэрбум төгрөг болж өмнөх оноос 57.3 хувиар буурсан нь голлон нөлөөлөөд байна.

ТӨСВИЙН ЗАРЛАГА
(зарлагын ангиллаар, их наяд төгрөг)



- Төсвийн зарлага 2025 оны 3 дугаар сард 6.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 807.4 тэрбум төгрөг буюу 14.2 хувиар нэмэгдсэн байна.
- Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийг 2025.01.01-ны өдрөөс инфляцын түвшинд уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлсэн.
- Цалингийн хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 1.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 39.8 хувиар, тэтгэвэр, тэтгэмж 2.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.7 хувиар тус тус өссөн байна.


ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)
(Зүүн тэнхлэг: их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)



- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2024 оны эцэст 33.4 их наяд төгрөгт хүрч, ДНБ-д эзлэх хувь 41.8 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 3 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар өсөж, 41.5 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 2 дугаар сард 38.4 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 38.0 хувьд хүрлээ.



- Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 3 дугаар сарын эцэст 41.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 10.9 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 10.7 нэгж хувь, төгрөгийн харилцах 0.7 нэгж хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.1 нэгж хувь, гадаад валютын хадгаламж 1.2 нэгж хувь, гадаад валютын харилцах -1.9 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.



- Нийт хадгаламж 27.1 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 19.7 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 22.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.0 хувиар, өмнөх сараас 0.2 хувиар буурлаа.
- Гадаад валютын хадгаламж 5.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.4 хувиар, өмнөх сараас 4.2 хувиар өслөө.




- Банкнуудын зээлийн үлдэгдэл 2025 оны 2 дугаар сарын эцэст 38.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 38.0 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.1 нэгж хувиар буурсан байна.



- Банкнуудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 2 дугаар сард 17.1 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар өслөө.
- Банкнуудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 2 дугаар сард 11.3 хувь болж, өмнөх сараас 0.2 нэгж хувиар буурлаа.



Эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр хөдөлмөрийн зах зээл идэвхжиж 2024 оны 4 дүгээр улиралд ажилчдын тоо 1 сая 353 мянга, ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувьд хүрлээ.




- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 31 мянга буюу 2 хувиар нэмэгдэж 1 сая 353 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 165 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2024 оны 4 дүгээр улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 21.8 мянгаар, эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 9.4 мянгаар тус тус өссөн байна.
- Ажилчдын тооны өсөлтөд үйлчилгээ ба бусад, худалдаа, барилгын салбарын ажилчид нэмэгдсэн нь эергээр нөлөөлсөн байна.
- Харин хөдөө аж ахуйн салбарын ажилчид, мөн боловсруулах, уул уурхайн салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөллөө.
- Ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар, цар тахлын өмнөх үеэс 1.5 нэгж хувиар өслөө.
- Харин ажилгүй иргэдийн тоо 2024 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 22 мянган хүнээр өсөж 75.4 мянгад хүрсэн байна. Ингэснээр ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар өсөж 5.3 хувьд хүрчээ.
- Дундаж цалингийн хэмжээ 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 19.5 хувиар өсөж, 2 сая 672 мянган төгрөгт хүрлээ.
- Улсын голч цалин 2024 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 25 хувиар өсөж, 2 сая 229 мянган төгрөг (дундаж цалингаас 442 мянган төгрөгөөр бага) болов. Энэ нь ажилчдын талаас илүү нь дундаж цалингаас бага цалин авч байгааг илэрхийлж байна.
- Салбараар авч үзвэл уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж улсын дунджаас 2 дахин өндөр байна.



Өрхийн бодит орлого сүүлийн 7 улирал дараалан өссөн ч өсөлтийн хурд саарлаа.

ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ
(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Өрхийн бодит орлогын өсөлт 5.9 хувь болж, өсөлтийн хурд суурийн нөлөөгөөр саарлаа.
- Бодит орлогын өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс 233 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 76 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.


БОДИТ ОРЛОГЫН БҮТЭЦ
(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Өрхийн дундаж бодит орлогод эзлэх цалингийн орлогын хэмжээ 57.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.3 нэгж хувиар нэмэгдсэн байна.
- Үүнд дундаж цалингийн өсөлтөөс гадна хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн нь нөлөөлж байна.


ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО
(сая төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бага орлоготой өрхийн орлого төдийлөн өсөхгүй байна.
- Нийт өрхийн 43.7 хувийг бүрдүүлж буй 1.6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого оны үнээр 981 мянган төгрөг байна.
- Харин 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого 3,207 мянган төгрөг байна.

ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО
(сая төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Нийслэлийн өрхийн дундаж орлого 3.1 сая төгрөгт хүрсэн бол хөдөө орон нутгийн өрхийн орлого бага байна.
- Нийслэлийн өрхийн орлогын 65.4 хувийг цалингийн орлого бүрдүүлж байхад хөдөөгийн өрхийн орлогын 15.2 хувийг цалингийн орлого, 37 хувийг хөдөө аж ахуйн орлого бүрдүүлж байна.



Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 1 дүгээр улиралд 266.1 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 25.2 мянгаар буюу 10.5 хувиар нэмэгдлээ.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО
(мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)




- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 1 дүгээр улиралд 266.1 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 25.2 мянгаар буюу 10.5 хувиар нэмэгдлээ.
- Уг өсөлтийн 18.3 мянгыг үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 7.9 мянгыг үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүллээ.
- Үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдэж байгаа нь бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ
(ААН-ийн тоо, салбараар)




- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН 4.6 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 49 хувиар өссөн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО
(мянга, ажиллагчдын тоогоор)



- Үйл ажиллагаа явуулж буй 109.8 мянган ААН-ийн 94.8 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн өсөлтийн 92 хувийг бүрдүүлж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС
(улирлаар, 2018=100)



- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2025 оны 1 дүгээр улиралд 104.4-д хүрч өмнөх оны мөн үеэс 4.6 нэгжээр сайжирлаа.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 19.6 нэгжээр нэмэгдсэн. Үүнд хэрэглэгчдийн ажлын олдцын үнэлэмж сайжирсан нь нөлөөллөө.
- Харин эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 0.2 нэгжээр буурсан бөгөөд үүнд бизнесийн нөхцөлийн хүлээлт муудсан нь нөлөөллөө.




ОХУ-ын эдийн засаг 2024 онд 4.3 хувиар өслөө. Инфляцын түвшин 2025 оны 3 дугаар сард 10.3 хувьд хүрч, өмнөх сараас 0.2 нэгж хувиар өслөө. Төв банкнаас бодлогын хүүг 2024 оны 10 дугаар сард 2 нэгж хувиар өсгөж, 21 хувьд хүргээд байна.




ОХУ-ын статистикийн хорооноос 2024 оны эдийн засгийн өсөлтийн 4.1 хувиас 4.3 хувь болгон шинэчлэн зарлалаа.



- 2025 оны 2 дугаар сарын байдлаар экспорт 30.9 тэрбум ам.доллар, импорт 20.4 тэрбум ам.долларт тус тус хүрч, худалдааны тэнцэл 10.5 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2025 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар буурлаа.
- Импорт 2025 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өслөө.



- Инфляцын түвшин 2025 оны 3 дугаар сард 10.3 хувь болж, өмнөх сараас 0.2 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 2.4 нэгж хувиар тус тус өссөн байна.
- ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.
- ОХУ-ын төв банкнаас 10 дугаар сарын 25-ны өдөр бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 21 хувьд хүргэх шийдвэр гаргасан.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2025 оны 3 дугаар сард 48.2 болж, өмнөх сараас 2 нэгжээр буурлаа.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2025 оны 2 дугаар сарын байдлаар 0.2 хувь болж, өмнөх сараас 2 нэгж буурлаа.



БНХАУ-ын эдийн засаг 2025 оны эхний улиралд 5.4 хувиар өслөө. 2025 оны 3 дугаар сард экспортын өсөлт эрчимжиж, аж үйлдвэрийн гарцын өсөлт 2021 оны 6 сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрлээ.




- БНХАУ-ын эдийн засаг 2025 оны эхний улиралд 5.4 хувиар өслөө.
- Худалдааны дайны нөлөөгөөр экспортын жилийн өсөлт 2025 оны 3 дугаар сард 12.4 хувьд хүрч эрчимжлээ.
- Импорт 2025 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар буурлаа.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик 3 дугаар сард нэгтгэгдэн зарлагдаг.




- Аж үйлдвэрийн гарцын өсөлт 2025 оны 3 дугаар сард 7.7 хувьд хүрч, 2021 оны 6 дугаар сараас хойш хамгийн өндөр түвшинд хүрлээ.
- Засгийн газраас авч хэрэгжүүлж буй хэрэглээг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийн нөлөөгөөр жижиглэн худалдааны өсөлт 2025 оны 3 дугаар сард 5.9 хувьд хүрч эрчимжлээ.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик 3 дугаар сард нэгтгэгдэн зарлагдаг.



- Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт 2025 оны 3 дугаар сард -0.1 хувь гарлаа.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн жилийн өөрчлөлт 2025 оны 3 дугаар сард -2.5 хувь гарч, үнийн уналт үргэлжилж байна.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2025 оны 3 дугаар сард 50.5 болж, өмнөх сараас өслөө.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас нэмэгдлээ.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхжиллийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажиг эрхлэлт, түүний эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ